

# МОНГОЛБАНКНЫ МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ХУРААНГУЙ ТЭМДЭГЛЭЛ

---

№ 19/4

Улаанбаатар хот

Мөнгөний бодлогын хороо (МБХ) 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдөр хуралдаж, хуралдааныг Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн удирдав. Хуралдаанаар мөнгөний бодлогын хүү болон заавал байлгах нөөцийн хувь хэмжээг өөрчлөх эсэх талаар хэлэлцлээ.

МБХ-ны хуралдаанд макро эдийн засгийн өнөөгийн болон ирээдүйн төлөв, санхүүгийн зах зээл, гадаад, дотоод орчны тодорхой бус байдлын талаар Монголбанкны Мөнгөний бодлогын газар (МБГ)-аас танилцуулав.

Инфляци энэ оны 3-р улиралд төсөөллөөс бага зэрэг өндөр гарсан ч оны эцэст буурч, өмнөх төсөөллөөс нам түвшинд хүрэхээр байгааг танилцууллаа. Тодруулбал, 11-р сард мах, хүнсний ногооны үнэ эрчимтэй буурсан (цаашид махны үнийн өсөлтийн өмнөх оны сүүлээр огцом өссөн нөлөө арилах), агаарын тээврийн үйлчилгээ хямдарсан, хатуу түлш болон импортын барааны үнийн өсөлт хүлээлтээс бага гарахаар байгаа нь 2019 оны инфляцийг бууруулж байгаа бол дунд хугацаанд инфляци зорилтот түвшин (8%)-ий орчимд тогтворжих төлөвтэй байна. Ирэх онд нийлүүлэлтийн хүчин зүйлсийн нөлөө аажмаар саарч байгаа ч төсөв, цалин болон ханшийн шалтгаантай эрэлтийн инфляци нэмэгдэн инфляцийг зорилтот түвшний орчимд тогтворжуулахаар байна.

Эдийн засаг эхний 3 улиралд 6.3 хувиар өссөн хэдий ч моментум таатай бус байгааг онцоллоо. Эрэлт талаас хэрэглээ, хөрөнгө оруулалтын өсөлт эдийн засгийн өсөлтийг тэтгэж байгаа ч сүүлийн улиралд удаашрах хандлагатай болсон. Харин нийлүүлэлт талаас эхний 3 улиралд уул уурхайн салбарын өсөлт эрчимжиж 7.3 хувьд хүрсэн бол уул уурхайн бус салбарын өсөлт удааширч 6 хувьд хүрсэн болохыг танилцуулав. Цаашид эдийн засгийн өсөлтөд төсвийн бодлогын төлөв, цалингийн өсөлтийг дагасан дотоод эрэлт эерэг нөлөөтэй, харин түүхий эдийн үнэ, гадаад эрэлтийн төлөв муудахаар байгаа нь сөрөг нөлөөтэй болохыг дурдав.

Мөн ажилгүйдлийн түвшин нэмэгдэж, ажил эрхлэлт буурч байгаа нь хөдөлмөрийн зах дээр идэвхжил сул байгааг илэрхийлж байгааг онцоллоо.

2019 оны эхний 11 сарын байдлаар төсвийн тэнцвэржүүлсэн орлогын өсөлт 17.7 хувь, зардлын өсөлт 15.5 хувьтай гарлаа. Цаашид төсвийн зардлын

гүйцэтгэл эрчимжиж, төсвийн төлөв 2019 онд 2 хувиар, 2020 онд 3.9 хувиар сулрах төсөөлөлтэй байгааг МБГ-ын зүгээс танилцуулав. Энэ нь нэг талдаа барилгын материалын импортыг нэмэгдүүлэх, эдийн засгийн өсөлтийг дэмжих бол нөгөө талаас эрэлтийн шалтгаантай инфляцийн дарамтыг үүсгэж болзошгүй.

Банкны зээлийн өсөлт саарлаа. Тодруулбал, макро зохистой бодлого хэрэглээний зээл саарахад нөлөөлж байгаа бол Активын чанарын үнэлгээ болон хяналт шалгалтын хууль журмуудын өөрчлөлт бизнесийн зээлийн нийлүүлэлтийг бууруулах нөлөө үзүүлж байна. Түүнчлэн чанаргүй зээлийн хэмжээ буурахгүй байгаа нь зээлийн өсөлтөнд сөргөөр нөлөөлж байгаа бөгөөд хэрэглээний зээлийн өсөлт үргэлжлэн саарч, бизнесийн зээлийн өсөлт нэмэгдэхээргүй байна.

Төлбөрийн тэнцэл 2019 оны 3 дугаар улиралд 192 сая ам.долларын алдагдалтай гарсан бөгөөд төсөөллөөр төлбөрийн тэнцэл 2019 онд ашигтай, 2020 онд алдагдалтай гарахаар байгааг танилцуулав. Төлбөрийн тэнцэл 2019 онд ашигтай гарахад 1) оны эхнээс экспортын үнэ харьцангуй өндөр түвшинд хадгалагдсан, 2) нийт импорт 2019 онд төдийлөн нэмэгдээгүй, 3) бизнесийн үйлчилгээний алдагдал буурч, тээвэр, аяллын орлого өссөнөөр үйлчилгээний данс сайжрахаар байгаа, 4) хувийн секторын гадаад зах дээр арилжаалсан 740 сая ам.долларын бонд болон ӨСХ-ийн хүрээнд хандивлагч орнуудын зүгээс 2019 онд 443 сая ам.доллар орж ирэхээр байгаа нь гол эерэг нөлөөг үзүүлэхээр байна. Харин 2020 онд алдагдалтай гарахад 1) дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнэ буурах, 2) Оюу толгойн зэсийн баяжмал дахь алтны агууламж буурах нөлөөгөөр экспортын орлого татрах, 3) цалин нэмэгдэх, төсвийн хөрөнгө оруулалтыг даган барааны импорт өсөх зэрэг нь нөлөөлөхөөр байгааг дурдав. Энэхүү төсөөлөлд ӨСХ-ийн хүрээнд донор санхүүжилтүүд үргэлжлэх, Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалтын хөрөнгө оруулалт хуваарийн дагуу хийгдэх нөхцөлийг харгалзан үзжээ.

Гадаад эдийн засгийн төлөв хүлээлтээс муудсан болохыг танилцуулсан бөгөөд том гүрнүүдийн худалдааны дайн, геополитикийн асуудлууд нь дэлхийн эдийн засгийн өсөлт, түүхий эдийн үнэ, хөгжиж буй орнуудыг чиглэх хөрөнгийн урсгалын цаашдын төлөвийн тодорхой бус байдлын гол эх сурвалж болж байгааг онцоллоо.

Танилцуулгын төгсгөлд пассивын долларжилт болон заавал байлгах нөөц (ЗБН)-ийн хувь хэмжээний өөрчлөлтийн талаар холбогдох тооцооллыг МБГ-аас танилцуулав. Олон улсад банкны эх үүсвэрийн долларжилтыг бууруулж,

гадаад валютаар эх үүсвэр татах сэдлийг бууруулах зорилгоор заавал байлгах нөөцийн хувийг гадаад валютын эх үүсвэрт өндрөөр тогтоох макро зохистой бодлогын арга хэмжээг түгээмэл авч хэрэгжүүлдэг байна. ЗБН-ийн хувийг гадаад валютын хувьд өндрөөр тогтооход 1) банкууд гадаад валютын хадгаламжийн хүүгээ бууруулж, ам.долларын өгөөж буурах, 2) төгрөгийн гадаад валюттай харьцах ханш сулрах үед эдийн засагт бий болох харилцах, хадгаламжийн хөрвөлтөөс сэргийлэх, 3) банкны гадаад валютын нээлттэй позици богиносгох дарамт буурах, 4) санхүүгийн долларжилтыг бууруулж, улмаар төгрөгийн ханшийн хэлбэлзлийг багасгах үр нөлөөтэй гэж үздэг болохыг танилцуулав.

Мөнгөний бодлогын газрын зүгээс бодлогын хүүг 0.5 нэгж хувиар бууруулж 10.5 хувьд хүргэх санал гаргасныг МБХ-ны гишүүд хэлэлцлээ.

Мөнгөний бодлогын хорооны гишүүд банкны салбарын зээл зогсонги байдалд орж байгаа, эдийн засгийн өсөлт удааширч байгаа өнөө үед ямар нэг арга хэмжээгээр эдийн засагт дохио өгөх шаардлагатай байгаатай санал нэгдсэн хэдий ч уг дохиог цаг хугацааны хувьд одоо өгөхөд тодорхой бус байдал өндөр байгаа тул энэ удаад бодлогын хүүг хэвээр хадгалах нь зүйтэй гэсэн саналыг дэвшүүлсэн.

Нөгөө талаас инфляцийн хувьд харьцангуй дарамт багатай байгаа үед эдийн засгийн өсөлтийг дэмжих, ажилгүйдлийг бууруулах зорилгоор бодлогын хүүг 0.5 нэгж хувиар бууруулах нь зүйтэй гэж зарим гишүүд үзсэн. Мөн Монголбанк хүлээлтээс өөрөөр шийдвэр гаргах нь эдийн засагт илүү нөлөөтэй болохыг дурдаж байв.

Өөр нэг гишүүний хувьд өвлийн улиралд манай орны эдийн засгийн идэвхжил харьцангуй сул байдаг тул бодлогын хүүг өөрчлөх нь төдийлөн том нөлөөгүй гэж үзсэн хэдий ч компаниудын дараа оны бизнес төлөвлөгөө хийгдэж байгаа өнөө үед Монголбанк цаашид эдийн засгийн өсөлтийг дэмжинэ гэсэн дохиог иргэдэд өгч, хүүгээ бууруулах боломжтой гэж үзэж байв.

Бусад гишүүдийн хувьд жилийн эцсийн тоонууд гарахаар эдийн засгийн цаашдын төлөв илүү тодорхой харагдана, мөн төсвийн гүйцэтгэл болон гадаад орчны тодорхой бус байдлуудыг харгалзан үзээд өнөөдрийн хувьд бодлогын хүүг хэвээр нь хадгалах нь зөв гэж дүгнэв. Мөн зээл олголт буурсан үед санхүүгийн зуучлал талаас бодлогын хүүг бууруулах нь бодит эдийн засагт харьцангуй бага нөлөөтэй байж болох талаар гишүүд дурдсан.

Ийнхүү, Мөнгөний бодлогын хорооны 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн ээлжит хуралдаанд нийт 5 гишүүн оролцсоноос 2 гишүүн бодлогын

хүүг 0.5 нэгж хувиар бууруулж 10.5 хувьд хүргэх, 3 гишүүн 11 хувьд хэвээр хадгалах санал гаргалаа. Эдийн засгийн өсөлт болон зээлийн өсөлт саарах хандлагатай холбоотойгоор Мөнгөний бодлогын хороо бодлогын хүүг бууруулах хувилбарыг хэлэлцсэн хэдий ч төсвийн гүйцэтгэл, гадаад орчны тодорхой бус байдлыг харгалзан үзээд нийт 60 хувийн буюу ердийн олонхийн саналаар энэ удаад бодлогын хүүг өөрчлөхгүй байхаар шийдвэрлэв.

Мөнгөний бодлогын газрын зүгээс ЗБН-ийн хувийг төгрөгийн эх үүсвэрийн хувьд хэвээр хадгалж, гадаад валютаарх эх үүсвэрийн хувьд 3.0 нэгж хувиар нэмэгдүүлж 15 хувьд хүргэх санал гаргасныг МБХ-ны гишүүд хэлэлцлээ.

Хурлаар гишүүд банкны актив талд долларжилт буурч байгаа ч пассив талдаа долларжилт 28 хувьд хүрч нэмэгдээд явж байгаа, энэ хандлагыг зогсоох үүднээс тодорхой арга хэмжээнүүдийг авах ёстой учир ЗБН-ийн хувийг өсгөх арга хэмжээг авах нь зүйтэй гэж үзсэн.

Мөн хурлаар Монгол улсад төгрөгийн, долларын, юаны, еврогийн гээд бүх төрлийн хадгаламжийн үйлчилгээг харьцангуй чөлөөтэй олгодог нь эдийн засагт ачаалал үүсгэх эрсдэлтэй болохыг дурдсан бөгөөд гадны улсуудын туршлагаас харахад ингэж чөлөөтэй байх нь харьцангуй ховор байдаг байна. Тодруулбал, иргэнд валютын харилцах, гадаад худалдааны компанид валютын хадгаламж шаардлагагүй гэж үзэж байгаагаа илэрхийлэв.

Үлдсэн гишүүдийн хувьд валютын ханшийг хамгаалах үүднээс банкны ЗБН-ийн хувийг долларын хувьд нэмэх нь зүйтэй гэж үзлээ.

Ийнхүү, Мөнгөний бодлогын хорооноос төгрөгийн харьцангуй өгөөжийг хадгалах, улмаар төгрөгийн ханшийн хэлбэлзлийг бууруулах зорилгоор гадаад валютын заавал байлгах нөөцийн хувийг 3 нэгж хувиар нэмэгдүүлэх саналыг 100 хувь дэмжив.

## **ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:**

Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн ээлжит хурлаар Бодлогын хүүг 11 хувьд, Банкны төгрөгийн заавал байлгах нөөцийн хувь хэмжээг 10.5 хувьд хэвээр хадгалах, гадаад валютын заавал байлгах нөөцийн хувь хэмжээг 3 нэгж хувиар нэмэгдүүлж, 15 хувиар тогтоох шийдвэрийг гаргалаа.